



3-Р САРЫН ТАЙЛАН

ХЭ	АНХ	ХАН	-САН
РЭ	ЭНХ	ХЭН	-СЭН
СЭ	ОНХ	ХОН	-СОН
ХӨ	МӨНХ	ХУН	-СӨН



ТООН ҮЗҮҮЛЭЛТ

3-Р САР

2021.03.31

НИЙТ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ

14

ХАРЬЯА ДҮҮРЭГ, ХОРООНД
ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН

- 6

МЭРГЭЖИЛТЭНД
ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН

- 4

Хүйс



Нас



Тайлбар

Ид шидийн орон ХХХТ-н түр хамгаалах байранд 2021 оны 3 сард шинээр 14 үйлчлүүлэгч хүлээн авч үйлчилгээнд хамруулсан. Мөн энэ сард 6 үйлчлүүлэгчийг ар гэрт нь эргэн нэгтгэхээр харьяа дүүрэг, хорооны хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэн өгч, 4 үйлчлүүлэгчийг хариуцсан мэргэжилтэнд нь хүлээлгэн өгсөн. Өнөөдрийн байдлаар 14 үйлчлүүлэгч хамгаалах байрны цогц үйлчилгээг авч байна. Үүний 9 эмэгтэй, 5 эрэгтэй. 1-5 насны 3 үйлчлүүлэгч, 6-10 насны 6 үйлчлүүлэгч, 11-13 насны 5 үйлчлүүлэгч байна

ТӨРСӨН ӨДӨР

ХАМГААЛАХ БАЙРАНД БАЙРЛАН ҮЙЛЧИЛГЭЭ АВЧ БАЙГАА
2 ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ТӨРСӨН ӨДРИЙН БАЯР ТОХИОЖ БАГШ
АЖИЛЧДЫН ХАМТ АГААРТ ГАРЧ БАЯРАА ХАМТДАА ТЭМДЭГЛЭСЭН.




Ид шидийн орон хүүхдийн түр хамгаалах байранд байрлан үйлчилгээ авч байгаа 10-с дээш насны үйлчлүүлэгчид хэрээсэн хатгамал болон шигтгээ наамал хийж сурч байна.



ТҮР ХАМГААЛАХ БАЙРНЫ ДЭЛГҮҮРИЙН МЭДЭЭ

Хүүхдүүд маань дэлгүүрийн бараанаасаа өөрсдийн хэрэгцээндээ тохируулан хичээлийн хэрэгсэл, гоёл чимэглэл, дотуур хувцас, ариун цэврийн хэрэгсэл зэргийг худалдан авдаг. Өнөөдрийн худалдан авалтаар дэвтэр их зарагдаж байна.



7 ХОНОГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГӨӨ ГАРГАНА Л ГЭНЭ ШҮҮ

Хоолоо идэх, хичээлээ хийх, ном унших зэрэг нь хамгийн чухал таскууд байлаа. Ид шидийн орон ХХХТ-ийн түр хамгаалах байрны адтай бяцханууд 7 хоногийн төлөвлөгөө гаргадаг. Багш нартаа төлөвлөгөөнийхөө биелэлтийг бас тайлагнана аа. Багш нар нь мэдээж төлөвлөгөөнийх нь дагуу үйл ажиллагаагаа явуулахыг хичээнэ гэж байгаа



Төлөвлөгөөний хуудас

НЭР: _____

ДАВАА ГАРИГ

1. Хийгээд хийнэ _____
2. Анги хэлний дүршилэндээ ордон _____
3. Тоглон _____
4. Дүү сансан _____
5. Зурагт үзнэ _____

МЯГМАР ГАРИГ

1. Хийгээд хийнэ _____
2. Цугалдан авалтаа хийнэ _____
3. Тоглон _____
4. Зурагт үзнэ _____
5. Хоолоо иднэ _____

ЛХАГВА ГАРИГ

1. Хийгээд сайн хийнэ _____
2. Цсанг орон _____
3. Дүү сансан _____
4. Тоглон _____
5. Одог бүрийг эрт сурталчилуулна _____

ПҮРЭВ ГАРИГ

1. Сэтгэл зүйлтэй үздэн _____
2. Цээг андлуулна _____
3. Бүрэл, гол дэлгэцтэй бүлэгтэртнэ _____
4. Хийгээд хийнэ _____
5. Даалавараа хийнэ _____

БААСАН ГАРИГ

1. Анги хэлгээ оро _____
2. Хийгээд хийнэ _____
3. Тоглон _____
4. Зурагт үзнэ _____
5. Хувиасаа эвсэн _____

БЯМБА ГАРИГ

1. Шүрэл рожлоо _____
2. Хийгээд хийнэ _____
3. Дүү сансан _____
4. Тоглон _____
5. Нам үншин _____

НИЙМ ГАРИГ

1. Хувиасаа улаан _____
2. Нам үншин _____
3. Дүү сансан _____
4. Шүрэл рожлоо _____
5. Хоолоо иднэ _____



ЦАХИМ ХИЧЭЭЛ

Түр хамгаалах байрны үйлчлүүлэгч хүүхдүүд маань цахим хичээл болон хичээлийн хоцрогдол арилгах нэмэлт давтлага хичээлдээ тогтмол хамрагдаж байна. Үйлчлүүлэгчийн амьдралын орчин нөхцөл, хүчирхийллийн хэлбэр зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан дийлэнхи хүүхдүүд маань хичээлийн хоцрогдол ихтэй, сургууль завсардсан байдаг. Бид өдөр бүр, бага багаар хичээллэсээр байна.




**БҮХ ЮМНЫ ДАРГА ӨВӨР ДЭЭР ИРЖ СУУЧИХААД БУУХГҮЙ
"АЖИЛ ХИЙНЭ" ГЭЭД СУУГААД БАЙНА, СУУЖ Л БАЙГ УУ...**



Ид шидийн орон ХХХТ-ийн түр хамгаалах байрны бяцхан үйлчлүүлэгч хүүхдүүд маань бага багаар суралцсаар л байна. EQ буюу сэтгэл хөдлөлийн чадамж нь хүүхдийг насанд хүрэхэд сэтгэл зүйн хувьд эрүүл байх, сэтгэлийн хөдөлгөөнөө зөвөөр илэрхийлэхэд нь хамгийн гол хүчин зүйл болж байдаг чухал ойлголт юм. Бид тэр бүр хүүхдүүддээ энэ чадварыг суулгах, хөгжүүлэх тал дээр анхаардаггүй. EQ сайтай хүмүүс өөрийнхөө сэтгэлийн хөдөлгөөнийг маш сайн зохицуулж чаддаг. Хүн болгонд үндсэн сэтгэлийн хөдөлгөөнүүд бүгд байдаг бөгөөд энэхүү сэтгэлийн хөдөлгөөнөө зохицуулах нь насны хөгжлийн үе шатаар ахиж байдаг.





Манай нэг хүүхэд нохойнд их хайртай, одоохондоо
бүрэн хэлд ороогүй, дохио зангаагаар нохой унтаж байна,
нохой хоолоо идсэн гэх мэтээр бүгдийг ойлгуулна.
Амьтадтай танилцах, үр төлийг нь таних хичээлийн үеэр тэр нохойны
картнаас огт салсангүй. Дугарч, хөдөлж үзүүлж байна.
Хорвоо ертөнцтэй танилцаж явна



ТҮР ХАМГААЛАХ БАЙРНЫ БАГАЧУУДЫН ЦАГ

Сургуулийн өмнөх насны болон бага ангийн хүүхдүүдийн гарын жижиг булчинг хөгжүүлэх нь чухал байдаг. Бугуйн хөдөлгөөнийг сайжруулах, гарын жижиг булчинг хөгжүүлэх зэрэг нь гарын эвсэл, уян хатан байдал, хөдөлгөөнийг дэмжих зэрэгт чухал ач холбогдолтой. Цаашлаад хүүхэд том болох тусам зурах, бичих, наах, оёх зэрэг үйлдлүүд хийхэд гар амархан ядрах, чилэх, эв дүйгээ олохгүй байх зэрэг асуудлууд үүсэхээс сэргийлэх юм.

Зураг дээрхи дасгалыг хийснээр багачууд маань гарын жижиг булчинг хөгжүүлэх, бугуйн хөдөлгөөнийг дэмжихээс гадна өнгө таниж сурч байгаа юм. Өдөр бүр бага багаар суралцсаар явна.

Ид шидтэй ах эгч нар минь гарын доорх материал ашиглан хөнгөн, зугаатай дасгалуудыг хүүхдүүдтэйгээ хамт хийгээрэй.






ГАДАА ДУЛААРААД
ХҮҮХДҮҮД МААНЬ НАРЛААД, ТОГЛООД
САЙХАН ӨДӨР БАЙНА АА.



Өдрийн хоолоо идсэн үү
Ид шидтэй ах эгч нараа, хүүхдүүд маань
өдөр бүр амттай, амин дэмтэй хоол
идэж байгаа шүү.



ЛАНТУУ ХҮҮГИЙН НАЙЗ ЦАСАН ХҮН

Цасаар хүүхдүүд маань Лантуу хүүдээ найз хийж өглөө. Агаар цэвэр, гадаа дулаахан, шинэхэн цастай сайхан өдөр болж байна. Том багагүй бүгдээрээ л оролцлоо.



ХҮҮХДҮҮД МААНЬ МУНДАГ ХУВИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТТАЙ

Түр хамгаалах байрны үйлчлүүлэгч хүүхдүүд хувийн зохион байгуулалт сайтай гэж жигтэйхэн байгаа биз. **Хувцасны эвхэлт, эмх цэгц** гэж естой үзүүлж өгнө шүү дээ.



Аливаа зүйл багаасаа эхэлдэг. Бага насны үйлчлүүлэгч хүүхдүүд маань хувийн ариун цэврийг ягштал сахиж **өөрөө өөртөө хариуцлагатай байдаг** нь ямар хайр хүргэм гээч. Ид шидтэй ах эгч нарын хандиваар ирсэн хувцаснууд бяцхан эздэдээ очиж тэднийг минь баярлуулдаг юм шүү.



ЗӨВ ХҮН БОЛОН ТӨЛӨВШИЖ БАЙНА

Шатар, даам нүүнэ л гэнэ шүү. Ид шидийн орон ХХХТ түр хамгаалах байрны үйлчлүүлэгчид маань чөлөөт цагаа үр дүнтэй, зөв боловсон өнгөрүүлж байна.

Өдөр бүр багш нар нь хүүхдүүддээ тоглох цаг тусгайлан гаргадаг бөгөөд хөгжилтэй өдрүүд ид шидийн оронд өнгөрдөг. 2 бага насны үйлчлүүлэгч хөвгүүд маань тоглож байх явцдаа харилцан ярилцсан яриа нь багшийгаа их баярлуулсан.

За яахав энэ удаа чи хождог юм байж, гараа нь найз нь хожно оо, юм гэдэг ээлж гараатай, баяр хүргэе гэж хэлж байгаа нь хүүхдүүд маань зөв хүн хүн болж төлөвшиж байгааг харуулсан.



Үйлчлүүлэгч
хөвгүүн



Ид шидийн орон 1 түр хамгаалах байранд байгаа бүх үйлчлүүлэгчид маань урьдчилан сэргийлэх хяналтын үзлэгт тогтмол хамрагдаж байгаа.




Хавар болж дулаан цаг ирж байгаатай холбогдуулан үйлчлүүлэгч нар маань хичээлийн бус цагаараа аль болох л гадаа тоглон хөгжилдөж өнгөрөөж байна. Хаврын салхи хавирга нэвт гэсэн ардын сайхан зүйр үгийн дагуу багачуул маань бага зэргийн ханиад хүрцгээгээд зарим нэг нь утлага эмчилгээнд орж эхэлсэн. (2 настай бяцхан үйлчлүүлэгч маань эхний 2 өдөр утлагандаа орох гэж уйлж орилоод хийлгэхгүй байсан чинь 4 дэх өдрөөс ингэж маягийн барьж өөрөө утлагаа хийдэг болно гэнээ)

Түр хамгаалах байрны үйлчлүүлэгчдийнхээ дархлааг нэмэх, эрүүл мэндийг дэмжих зорилгоор шаардлагатай аминдэм, витаминуудыг тогтмол өгч байна.



“Ид шидийн орон” ХХХТ-1 –ийн нийт ажилчдынхаа болон үйлчлүүлэгчдийнхээ “Хаврын дархлаажуулалт” хийлээ.

Энэ сарын хамгийн бяцхан үйлчлүүлэгч маань 8 сартай гунж байлаа . ТХБ-нд нийт 7 хоног байралсан боловч шинээр ирсэн өдрийнхөө маргааш бие нь өвдөөд 3 шөнө 4 өдрийг эмнэлэгт мундаг эмч нарын эмчилгээн дунд өнгөрөөсөн. Бяцхан гүнжийг бүрэн гүйцэт эмчилгээгээ хийлгээд эрүүл саруул болоод эмчилгээний дараах гамаа сайтар барихаар болоод гэрийн зүг явсанд нь бид баяртай байгаа




ИШАЭ-ИЙН НОМЫН САН

14 хүүхдэд Монгол хэл, Математикийн хичээлийн хоцрогдол арилгах сургалтыг өдрийн 8 цагаар орсон

6 настай нэгэн сурагч маань уншиж, бичиж, бодож чаддаггүй байсан бол энд ирснээсээ хойш хичээнгүй суралцаар Монгол хэлний цагаан толгойн үсгээ үзэж дуусан, уншиж, бичиж сурлаа. Мөн 1-100 дотор бодож сурсан. Бөөн бөөн баяр.

–Багшаа би энд ирэхдээ юу ч мэддэггүй байсан тээ. Одоо бол дуртай номоо сонгож уншаад эрдэмтэн болж байна хэмээн гүйгээд л байна.



Багш:

Эр үг гэж ямар үгийг хэлэх вэ?

Сурагч:

Эрэгтэй үгнүүдийг хэлнэ ш дээ багшаа.

Багш:

Эрэгтэй үг гэж ямар үг байна?

Сурагч:

Унага, хав гээд үгнүүд чинь багшаа эрэгтэй үг ш дээ.



Математикийн хичээл дээр орон санах, зээлэх тоо заав.

Багш:

$80-16=$ хэд вэ?

Сурагч:


Бодож байснаа багшаа хойно нь 4, тэгээд 8-аас 1 нь нэг газар луу явсан юм чинь

7 тээ? гэнэ.



Миний хөөрхөн дүү

Ахлах ангийн сурагчдад “Миний хөөрхөн дүү” хэмээх эх зохиох даалгавар өгөхөд нэгэн сурагч маань ийн бичжээ. “Би дүүтэйгээ үүрд хамт амьдрахгүй. Ямар нэгэн хүчирхийлэл, айдас болгоноос дүүгээ үргэлж холдуулна.” Хэмээн бичжээ.



Classroom meeting

Сурагчдын ЕБС-ийн теле хичээлд нь амжилттай бүрэн хамруулсан.
Мөн 10-р ангийн нэгэн сурагчаа классрүүмд холбогдон,
meet-ээр тогтмол хичээлд нь хамруулж байна.



ЗАРДЛЫН ТАЙЛАН

ХҮҮХЭД ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН ЗАРДАЛ

Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардал
Цэцэрлэгийн хангамжийн зардал
Сургалт, судалгаа, хөгжүүлэлтийн хэрэглэгдэхүүний зардал

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ХӨТӨЛБӨРИЙН ЗАРДАЛ

Хамгаалах байрны хүүхдийн хоолны зардал
Хамгаалах байрны хүүхдийн хувцас зардал
Хамгаалах байрны хүүхдийн ахуйн хэрэглэлийн зардал
Сэтгэл заслын үйлчилгээний зардал
Хүүхэд хамгааллын нийгэмшүүлэх үйлчилгээний зардал
Хүүхэд хамгааллын үйлчилгээний эрүүл мэнд эм хангамж зардал
Хүүхэд хамгааллын үйлчилгээний хангамж зардал / үс замах анги цэвэрлэгээ хуримтлал
Бичиг хэргийн зардал
Томилотын зардал
Тусгай арга хэмжээ, баяр ёслол, шагналын зардал

АШИГЛАЛТЫН ЗАРДАЛ

Цахилгаан
Бохир ус
Цэвэр ус
Хог тээвэр
Интернет
Утас ид шидийн орон
Утас хамгаалах байр

ЦАЛИНГИЙН ЗАРДАЛ

Цалингийн зардал /хамгаалах байр /
Цалингийн зардал /Ид шидийн орон нэг /
Цалингийн хуримтлалын зардал
НДШ-ийн зардал /нийт цалин/

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

Ажилчдын хоолны зардал
Маркетингийн зардал
Ногоон байгууламжийн арчилгааны зардал
Цэвэрлэгээ, ариутгалын зардал
Барилгын засварын зардал
Тоног төхөөрөмжийн засварын зардал
Шетахууны зардал
Тээврийн зардал
Шетахууны зардал ид шидийг орон нэг
Тээврийн зардал ид шидийн орон нэг
Томилотын зардал ид шидийн орон нэг
Бичиг хэргийн зардал ид шидийн орон нэг
Сургалтын зардал
Unifont, үнэмлэх гм
Татварын зардал Үл хөдлөх, газар
Давтгалын зардал

НЭГДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

Тусгай арга хэмжээ, баяр ёслол, шагналын зардал
Бусад зардал \нотариат, орчуулга, карго\

ЦАЛИНГИЙН ЗАРДАЛ - 157%

14,566,611 ₮

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ЗАРДАЛ - 29%

2,650,000 ₮

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН
ХӨТӨЛБӨРИЙН ЗАРДАЛ - 3%

293,872 ₮

АШИГЛАЛТЫН ЗАРДАЛ
1,1%

102,458 ₮